



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/54

Номгон

Аймгийн 2021 оны төсвийн хуваарь
батлах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 2/09 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2021 оны төсвийн орлогын хуваарийг нэгдүгээр, орон нутгийн төсвийн байгууллагуудын хуваарийг хоёрдугаар, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн хуваарийг гуравдугаар, орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн хуваарийг дөрөвдүгээр, сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хуваарийг тавдугаар, орон нутгийн хөгжлийн сангийн хуваарийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төсвийг хуваарийн дагуу санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-д, төсвийн сар, улирлын хуваарийг баримтлан, батлагдсан төсвийн хүрээнд төсвийг үр ашигтай зарцуулахыг сумын Засаг дарга, орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210137